МЭДЭЭ · 2023 оны 10-р сарын 6

ШИНЭЭР ТОМИЛОГДСОН ПРОКУРОРУУД ЧАДАВХЖУУЛАХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАЖ БАЙНА



Аймаг, дүүргийн прокурорын газарт 2022-2023 онд шинээр томилогдон ажиллаж байгаа прокуроруудад зориулсан сургалт Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж байна.

Шинэ залуу прокуроруудыг чадавхжуулах зорилго бүхий тус сургалтын хүрээнд прокурорын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад хүний эрх, эрх чөлөө, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулахад анхаарах асуудлын талаар онцлон мэдээлэл өгч байна.





Энэ сарын 02-ны өдрөөс эхэлсэн тус сургалт таван өдөр үргэлжилж, өнөөдөр дуусч байна.

УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор Ц.Хашбаатар:



Прокурорын анхан шатны сургалтыг 2023 онд 3 дахь удаагаа зохион байгуулж байна. Энэ удаагийн сургалтын онцлог нь АНУ-ын Төрийн департаментын санхүүжилтээр Азийн сангаас хэрэгжүүлж буй “Залуу хуульчдыг чадавхжуулах замаар Монгол Улсын шүүх эрх мэдлийн тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн дэмжлэгтэйгээр судлаач, эрдэмтэд болон олон жил ажилласан дадлага, туршлага бүхий прокуроруудтай хамтран “Шинээр томилогдсон прокуроруудад зориулсан сургалтын гарын авлага”-ыг боловсруулсан.

Уг гарын авлагын агуулгыг бүрэн хамруулан сургалтыг зохион байгуулж, Улаанбаатар хотод томилогдсон 4, орон нутагт томилогдсон 29, нийт 33 прокурор хамрагдлаа. Сургалтаар прокурорын ёс зүй, хараат бус байдал, хяналтын ажлын онцлог, хавтаст хэрэг хянах арга зүй, хэргийн түүвэр хийх аргачлал, хувь хүний хөгжил, стресс менежмент зэрэг сэдвийн хүрээнд мэдээ, мэдээллийг өгч байна.



Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1670